

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Конвер ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayar@audit.gov.mn">otgonbayar@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Голден пэйж Аудит ХХК Захирал: С.Оюунгэрэл Утас: 70117179 Цахим хаяг: <a href="mailto:info@goldenpageaudit.mn">info@goldenpageaudit.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 530  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР  
ДҮҮРГИЙН КОНВЕР ӨЭМТ-ИЙН  
ДАРГА М.МӨНХЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Конвер ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Конвер ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 377.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Конвер ӨЭМТ-ийн гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/1077 дугаар захирамжаар 88.0 хувь, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлтийг 87.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	13,055,093.58	494,451.98
Бусад авлага	23,542,003.92	4,596,434.73
Бараа материал	9,532,016.47	14,500,194.96
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>46,129,113.97</b>	<b>19,591,081.67</b>
Үндсэн хөрөнгө	88,498,648.52	75,234,710.11
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>88,498,648.52</b>	<b>75,234,710.11</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>134,627,762.49</b>	<b>94,825,791.78</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
Дансны өглөг		200,000.00
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>9,293,159.28</b>	<b>6,013,220.72</b>
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>9,293,159.28</b>	<b>6,213,220.72</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>9,293,159.28</b>	<b>6,213,220.72</b>
<b>Өмч</b>	<b>18,070,181.00</b>	<b>18,070,181.00</b>
Төрийн	18,070,181.00	18,070,181.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Хуримтлагдсан ашиг	107,264,422.21	70,542,390.06
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>125,334,603.21</b>	<b>88,612,571.06</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>134,627,762.49</b>	<b>94,825,791.78</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Түрээсийн орлого (Санхүүжилтийн орлого)</b>	<b>421,313,367.52</b>	<b>377,175,025.60</b>
<b>Хүүний орлого</b>	<b>155,985.33</b>	<b>52,778.12</b>
<b>Бусад орлого (үнэгүй орлого, бусад)</b>	<b>63,001,419.24</b>	<b>14,412,069.86</b>
Ерөнхий удирдлагын зардал	432,362,469.77	428,361,905.73
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>52,108,302.32</b>	<b>(36,722,032.15)</b>
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>52,108,302.32</b>	<b>(36,722,032.15)</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>52,108,302.32</b>	<b>(36,722,032.15)</b>
<b>Бусад олз/ гарз</b>		-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>52,108,302.32</b>	<b>(36,722,032.15)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>416,069,852.16</b>	<b>400,971,536.81</b>
Татаас санхүүжилтийн орлого	330,235,041.83	396,120,594.79
Бусад мөнгөн орлого	85,834,810.33	4,850,942.02
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>401,558,043.74</b>	<b>409,742,178.41</b>
Ажиллагчдад төлсөн	290,224,258.00	293,110,584.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	27,087,363.06	30,064,009.14
Бараа материал худалдан авахад төлсөн	29,179,316.00	60,794,852.00
Ашиглалтын зардалд төлсөн	396,000.00	-
Бусад мөнгөн зарлага	54,671,106.68	25,772,733.27
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>14,511,808.42</b>	<b>(8,770,641.60)</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>1,500,000.00</b>	<b>3,790,000.00</b>
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө	1,500,000.00	3,790,000.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,500,000.00)</b>	<b>(3,790,000.00)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>13,011,808.42</b>	<b>(12,560,641.60)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>43,285.16</b>	<b>13,055,093.58</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>13,055,093.58</b>	<b>494,451.98</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>18,070,181.00</b>	<b>1,627,431.00</b>	<b>53,528,688.89</b>	<b>73,226,300.89</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			1,627,431.00	1,627,431.00
Залруулсан үлдэгдэл	18,070,181.00	1,627,431.00	55,156,119.89	74,853,731.89
Тайлант үеийн ашиг			52,108,302.32	52,108,302.32
Өмчид гарсан өөрчлөлт		(1,627,431.00)		(1,627,431.00)
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>18,070,181.00</b>	<b>-</b>	<b>107,264,422.21</b>	<b>125,334,603.21</b>
Тайлант үеийн ашиг			(36,722,032.15)	(36,722,032.15)
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>18,070,181.00</b>	<b>-</b>	<b>70,542,390.06</b>	<b>88,612,571.06</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,189.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 165.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 11,023.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэлт дутуу гүйлгээ хийсэн байна	1	3,365.5					1	3,365.5
Хөрөнгийн бүртгэлд үнэ цэнэгүй, үлдэх өртөггүй болсон хөрөнгө ашиглагдаж байна.	1						1	
Орлогыг дутуу бүртгэсэн байна.	1	2,086.0					1	2,086.0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>5,451.5</b>					<b>3</b>	<b>5,451.5</b>

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй шууд худалдан авсан байна.	1	61,782.6					1	61,782.6
Эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийн орлогоос урсгал засварт, байрны түрээсийн зардалд мөнгө зарцуулсан байна.	1	8,901.9			1	8,901.9		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>70,684.5</b>			<b>1</b>	<b>8,901.9</b>	<b>1</b>	<b>61,782.6</b>